# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРААС ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ, ҮР ДҮН

## 1. Нийслэлийн өмчийн барилга байгууламж, орон сууцны нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулж байна

Нийслэлээс олон жилийн турш алдагдсан өмч хөрөнгүүдийг эргүүлэн авах, ашиглалтыг нь сайжруулах, дахин төлөвлөх, дуудлага худалдаагаар борлуулж, олсон орлогоор нь сургууль, цэцэрлэг барих, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх зэрэг ажлыг үе шаттай хийж байна. Тухайлбал, нийслэлийн өмчид бүртгэлтэй ч бусдын хууль бус эзэмшилд олон жил болсон хөрөнгүүд буюу:

- НЗД-ын дэргэдэх Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийн харьяа "Дашчойлин" хийдийн баруун хойно байрлах эмийн үйлдвэрийн 3150 ам.метр газрыг чөлөөлсөн. Уг газрыг "Эхлэл брэнд" ХХК-д 9.3 тэрбум төгрөгөөр дуудлага худалдаагаар борлуулж, олсон орлогоор нь Улаанбаатар хотод зогссон, санхүүжилт нь шийдэгдэхгүй байгаа сургууль, цэцэрлэгийг барьж ашиглалтад оруулсан. Нийслэлээс 15 сургууль, цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулахад ийнхүү дэмжлэг үзүүлсэн.
- Баянгол дүүргийн 14 дүгээр хороо, хуучнаар Шуудангийн 24 дүгээр салбарын барилгыг "Вирео үсрэлт" ХХК нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж авч, 1.6 тэрбум төгрөгөөр худалдагдсан. Тэгвэл уг 1.6 тэрбум төгрөгийн орлогоор сургууль, цэцэрлэгийн сандал, ширээ, зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж зэргийг шийдвэрлэхээр болсон.

Нийслэлийн Өмчийн харилцааны газар 2025 он гарснаас хойш нийт 2 барилга байгууламж, 2 сууцны нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулаад байна. Эдгээр дуудлагын худалдаа дараах үе шаттай зохион байгуулагдсан.

- 2025 оны 07 дугаар сарын 21-ны өдөр Баянгол дүүргийн 14-р хороо Шуудангийн 24 дүгээр салбар байрлаж байсан барилга болон Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо Баруун сэлбэ үйлчилгээний төв Ж блок барилгыг хувьчлах нээлттэй дуудлагын худалдааг зарлаж, 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан. Тус дуудлагын худалдаагаар Баянгол дүүргийн 14-р хороо Шуудангийн 24 дүгээр салбар байрлаж байсан барилга 3 оролцогчтой байсан бөгөөд, 1.6 тэрбум төгрөгөөр "Вирео үсрэлт" ХХК-д худалдсан.
- 2025 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо Циркийн зүүн талд байрлах 1А байрны 1 орцны 1 тоотод байрлах орон сууц болон Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 4 дүгээр байрны 3 тоот орон сууцуудыг хувьчлах нээлттэй дуудлагын худалдааг зарлаж, 2025 оны 09 дугаар сарын 08-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо 1А байранд 1 оролцогч, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 4 дүгээр байранд оролцогчгүй байсан тул эхний дуудлага худалдааг цуцалсан.
- 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Баруун сэлбэ үйлчилгээний төв Ж блок болон 2 орон сууцны 2 дахь удаагийн дуудлага худалдааг зарлаж, 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулсан. Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Баруун сэлбэ" үйлчилгээний төвийн "Ж" блок барилгын дуудлагын худалдаанд дэнчин төлж 1 иргэн, 1 аж ахуйн нэгж оролцсон бөгөөд 1,960,014,738.00 /нэг тэрбум есөн зуун жаран сая арван дөрвөн мянга долоон

гучин найм/ төгрөгөөр Аж богд трейд ХХК-д, Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, Циркийн зүүн талд байрлах 1А байр, 1 дүгээр орц, 1 тоот орон сууцны дуудлагын худалдаанд дэнчин төлж 6 иргэн оролцсон бөгөөд 334,295,276.00 /Гурван зуун гучин дөрвөн сая хоёр зуун ерэн таван мянга хоёр зуун далан зургаан/ төгрөгөөр иргэн Б.Л-д тус тус худалдав.

- Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо 4 дүгээр байрны 3 тоот бүхий 2 өрөө, 46 м.кв талбайтай орон сууцны дуудлага худалдаанд оролцох хүсэлт ирээгүй бөгөөд дахин дуудлага худалдааг 2025 оны 10 дугаар сарын 02-ний өдөр зарлагдсан боловч дуудлагын худалдаанд оролцох хүсэлт ирээгүй байна.






## 2. Нийслэлийн илүүдэлтэй байр талбайг түрээслүүлэх сонгон шалгаруулалтыг тогтмол зохион байгуулж байна

Нийслэлээс Өмчийн харилцааны газар нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагын хувьд нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг багасгана, нийслэлийн өмчөөс төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлнэ гэсэн үндсэн чиг үүргийн хүрээнд

- Нийслэлийн ашиглалтгүй, илүүдэлтэй байгаа байр талбай;
- Нийслэлийн өмчит хуулийн этгээд нь өөрийн санхүүгийн тайланд бүртгэлтэй эд хөрөнгийг бусдад түрээслүүлэх, түрээслэх харилцаа;
- Өмчийн харилцааны газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй барилга, байгууламжийг зохих журмын дагуу түрээслэх ажлыг үе шаттай зохион байгуулдаг.

Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах процесс нь:

1. **Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээллэх** - Сонгон шалгаруулалт явагдахаас ажлын 14-өөс доошгүй өдрийн өмнө сонин болон НӨХГ-ын цахим хуудсанд зарласан өдрөөс шалгаруулах өдөр хүртэл байршуулан нийтэд зарлан мэдээллэнэ.
2. **Материал хүлээн авах** - Заасан хугацаанд ирсэн бүх материалыг бүртгэж, тусгай тэмдэглэл хөтлөх ба бүрдүүлбэр гүйцэд тохиолдолд хүлээн авч материалыг комисст хүлээлгэн өгнө.
3. **Шалгаруулалтыг дүгнэх** - Шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлагыг хангасан түрээслэх хамгийн өндөр үнийн санал өгсөн этгээдийг шалгаруулж, түрээсийн гэрээ байгуулна гэсэн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 65 дугаар тогтоолын дагуу хэрэгждэг.

Түрээслэгчийн сонгон шалгаруулах зар мэдээ байгууллагын үндсэн цахим хуудас https://www.umch.ub.gov.mn/ -ны сонгон шалгаруулалтад цэсэд байршдаг. 2025 он гарснаас

хойш нийт 127 сонгон шалгаруулалтын зар, мэдээ байршсан байна. Мөн сонгон шалгаруулалтад оролцох материал ирүүлээгүй болон ирүүлсэн материалын бүрэн бүтэн байдал хангалтгүй байснаас үүдэн сонгон шалгаруулалтыг цуцалж дахин зарлах процесс явагддаг.






2025-09-19

## Нийслэлийн Өргөө амаржих газрын гадаа зогсоолын талбайн хэсэгт байрлах 6.6 м.кв талбайг "хүнсний мухлаг"-ийн зориулалтаар түрээслэх талбайн түрээслэгчийг сонгон шалгаруулах зар

**Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга**

| № | Түрээслэх талбайн зориулалт | Байршил | Талбайн хэмжээ | Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Хүнсний мухлаг | Нийслэлийн Өргөө амаржих газрын гадаа зогсоолын талбай | 6.6 м.кв | 1 м.кв нь 15,000 (Арван таван мянган ) төгрөг (ашиглалтын зардал ороогүй дүнгээр) |

***Материал хүлээн авах, мэдээлэл авах хаяг:*** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-1, Хөвсгөл лейк сити товер- 8/1, 3 давхарт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 305 тоот өрөөнд /бичиг хэргийн өрөө/, Утас: 99936610

***Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл:*** Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам"-ийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулна

**Анхаарах зүйлс**

Материалыг зарласан хугацаанд иргэн, хуулийн этгээдийн нэр, байршил, холбоо барих утасны дугаар, зориулалт, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд бичиж, товъёг хийж битүүмжилсэн хэлбэрээр 2 хувь ирүүлнэ.

Материал дутуу болон хугацаа хоцорч ирүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хасна

Эрхэлсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гадгаа оролцогч өөрөө нотолж, ирүүлсэн материалын бүрдэл болон үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

- НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын COP1...
- А.Амартүвшин: Ирэх онд 51.080 өрхийн сууцыг...
- Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын...
- Онцлох ажил: 340 Гкал дулаан, 300 МВт...
- Ч.Төгсдэлгэр: Хотын төвийн барилгыг дахин...
- Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Нийслэлийн...
- Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Нийслэлийн...

холбоо барих

2025-08-29

## Нийслэлийн ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 1 давхарт үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийг шалгаруулах сонгон шалгаруулах зар

**Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга**

| № | Түрээслэх талбайн зориулалт | Байршил | Талбайн хэмжээ | Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | Үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэгч | Нийслэлийн ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 1 давхарт | 100 м.кв | 1 м.кв нь 15,000 (Арван таван мянган ) төгрөг (ашиглалтын зардал ороогүй дүнгээр) |

***Материал хүлээн авах, мэдээлэл авах хаяг:*** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-1, Хөвсгөл лейк сити товер- 8/1, 3 давхарт, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 305 тоот өрөөнд /бичиг хэргийн өрөө/, Утас: 99936610

***Түрээслэгчийг сонгон шалгаруулах зааврын талаарх товч мэдээлэл:*** Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам"-ийн дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулна

**Анхаарах зүйлс**

Материалыг зарласан хугацаанд иргэн, хуулийн этгээдийн нэр, байршил, холбоо барих утасны дугаар, зориулалт, бүрдүүлсэн материалын жагсаалт тус бүрийг дугтуйны гадна талд бичиж, товъёг хийж битүүмжилсэн хэлбэрээр 2 хувь ирүүлнэ.

Материал дутуу болон хугацаа хоцорч ирүүлсэн тохиолдолд үл маргах журмаар хасна

Эрхэлсэн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, туршлагатай, санхүүгийн чадвартай гадгаа оролцогч өөрөө нотолж, ирүүлсэн материалын бүрдэл болон үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан нэг оролцогчийг шалгаруулна.

**Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл**

| | |
|---|---|
| Сонгон шалгаруулалтын материал хүлээн | 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 10 цаг хүртэл |

- Сүхбаатар дүүргийн Иргэдэд үйлчлэх төр захиргааны...
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн Төв...
- Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа...
- Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын...
- Нийслэлийн Өргөө амаржих газарт эмийн...
- Нийслэлийн Өргөө амаржих газарт иргэйн...
- Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгт аягалгийн...

холбоо барих

### 3. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний мэдээллийг байгууллагын цахим хуудасны "Үйлчилгээ" цэсэд байршуулав

Байгууллагын цахим хуудасны https://www.umch.ub.gov.mn/p/173 "Үйлчилгээ" цэсэд Нийслэлийн Өмчийн харилцааны газраас иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний мэдээлэл буюу Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний төрөл, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, гэрээний төрлүүд, нийслэлийн өмчийн эд хөрөнгийн

түрээслэгчийг сонгон шалгаруулах процесс, өмч эзэмшүүлэх гэрээ болон хувьчлах процесс, хувьчлалын аргууд зэрэг мэдээллийг ил тод байршуулж иргэд, олон нийтийг цахимаар төрийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжоор хангаж ажилласан.






# НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ПРОЦЕСС

## 01

### Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээллэх

Сонгон шалгаруулалт явагдахаас ажлын 14-өөс доошгүй өдрийн өмнө сонин болон НӨХГ-ын цахим хуудсанд зарласан өдрөөс шалгаруулах өдөр хүртэл байршуулан нийтэд зарлан мэдээллэнэ.

## 02

### Материал хүлээн авах

Заасан хугацаанд ирсэн бүх материалыг бүртгэж, тусгай тэмдэглэл хөтлөх ба бүрдүүлбэр гүйцэд тохиолдолд хүлээн авч материалыг комисст хүлээлгэн өгнө.

## 03

### Шалгаруулалтыг дүгнэх

Шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлагыг хангасан түрээслэх хамгийн өндөр үнийн санал өгсөн этгээдийг шалгаруулж, түрээсийн гэрээ байгуулна.



### Гэрээ байгуулах

Нийслэлийн өмчит төсөвт байгууллагын удирдлагатай Өмчийн харилцааны газар зохион байгуулна.

### Гэрээний биелэлтийг дүгнэх

Гэрээний биелэлтийг Өмчийн харилцааны газрын даргын тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг" жил бүр дүгнэнэ.

### Дүгнэлтийн үр дүн

Гэрээний биелэлтийн дүнгээр "Бүрэн хангалттай" үнэлгээ авсан байгууллагыг шалгаруулж, Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулах саналыг НУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

### Дүгнэлтийн үр дүн

Гэрээний биелэлтийн дүнгээр "Хангалтгүй" үнэлгээ авсан удирдлагын гэрээг цуцлах, өөрчлөх тухай саналыг НУЗ-ийн хуралд танилцуулж, холбогдох эрх бүхий албан тушаалтнаар шийдвэр гаргуулна.

## Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ

WWW.UMCH.UB.GOV.MN
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР
(11)-31-63-45
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2014 ОНЫ 65 ДУГААР ТОГТООЛ

## ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ДООД ХЯЗГААР

- Түрээсийн төлбөр төлөх данс: Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сан
- Дансны дугаар: 100200000956 тоот данс



WWW.UMCH.UB.GOV.MN | НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР | (11)-31-63-45 | НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2014 ОНЫ 67 ДУГААР ТОГТООЛ

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ ПРОЦЕСС

**01**

**Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батална.**

**02**

**Нийслэлийн өмчийг хувьчлах ажлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч зохион байгуулна.**

**03**

**Нийслэлийн өмчийг хувьчлах тухай зар мэдээг 3-аас доошгүй сонингийн 3 дугаар нүүрэнд, НЗДТГ, НӨХГ-ын цахим хуудсанд хэвлэл мэдээллээр зарласан өдрөөс дуудлагын худалдаа явагдах өдөр хүртэл байршуулна.**

WWW.UMCH.UB.GOV.MN | НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР | (11)-31-63-45 | НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2014 ОНЫ 67 ДУГААР ТОГТООЛ

## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ АРГУУД

- Дуудлагаар худалдан хувьчлах
- Уралдаант шалгаруулалт /төсөл сонгон шалгаруулах/-аар хувьчлах
- Нийслэлийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг хувьчлах
- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр өөрчлөн байгуулах
- Нийслэлийн өмчит хуулийн этгээдийг татан буулгаж, эд хөрөнгийг хувьчлах
- Менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчлах
- Давуу эрхтэй тусгай төрлийн хувьцаа гаргах



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙГ ХУВЬЧЛАХ ПРОЦЕСС

### 01
**Дуудлага худалдааг явуулах шийдвэр гаргах**

Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн батална.

Дуудлага худалдаа явуулах хугацааг товлоно.

### 02
**Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээллэх**

Нийслэлийн өмчийг хувьчлах ажлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч зохион байгуулна.

Нийслэлийн өмчийг хувьчлах тухай зар мэдээг 3-аас доошгүй сонингийн 3 дугаар нүүрэнд, НЗДТГ, НӨХГ-ын цахим хуудсанд хэвлэл мэдээллээр зарласан өдрөөс дуудлагын худалдаа явагдах өдөр хүртэл байршуулна.

### 03
**Дуудлага худалдааг зохион байгуулах**

Дуудлага худалдааны оролцогчид дуудлага худалдаанд оролцох дэнчин байршуулж бүртгүүлнэ.

Дуудлага худалдааг зохион байгуулана.

### 04
**Шалгаруулалтыг дүгнэх**

Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах, хөрөнгийн эрх шилжүүлнэ.